*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны*
*98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ХБТХОХ-ИЙН ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АЖИЛТАН Д.СҮГЛЭГМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | 1.1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.9.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах | Холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 30.0 хувь | Холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг 100-аас доошгүй хувь хангаж ажилласан байна. | ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн бүрэлдэхүүн Усан хангамжийн хэсгийн Цэвэр усны шугамыг төвийн шугаманд холбох ажлын тендер мөн Усан хангамжийн хэсгийн ухаалаг тоолуур, усны алдагдал бууруулах төхөөрөмж худалдан авах ажиллагааны тендерийн материалыг зөвлөхүүд боловсруулан банкны худалдан авах ажиллагааны багаар батлуулан худалдан авах ажиллагааг дахин зарласан. Худалдан авах ажиллагааны талаар мэдээллийг орон нутгийн вебсайт болон Өдрийн сонин, Өнөөдрийн сонинд байршуулан олон нийтэд мэдээллэсэн. Тендерүүд 3 сарын 14, 5 сарын 31-нд нээсэн. Барааны дахин зарласан тендерт санал ирээгүй. Шинэ төсөл боловсруулан | 2024-01-02<br>2024-12-31 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тендерийг  дахин зарлах талаар Банк болон Компанитай ярилцаж байна. Усан хангамжийн хэсгийн Цэвэр усны шугамыг төвийн шугаманд холбох ажлын тендерт Престиж инженеринг ХХК шалгарч ажлын гэрээ байгуулсан. Ажил 2025 оны  1-р улиралд эхэлнэ. Төслийн Үерийн менежментийн хэсгийн худалдан авах ажиллагааны баримт бичгийг боловсруулан хянуулж банкаар батлуулан тендерийг зарласан. Тендерийг 5 сарын 22-нд нээсэн ба үнэлгээ хийгдэж байна. Төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулахтай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэж ТХН-ийг байгуулан, ажлаа эхлүүлээд байна.  ТХН-ийн орон тоог шинэчлэн батлуулах болон ажилтнуудыг томилуулах тухай албан бичгийг Сангийн яаманд хүргүүлэн холбогдох тушаалыг гаргуулж хүлээн авсан. Мөн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг хянуулан байгуулсан. ТХН-ийг Сангийн яамны “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем” /ODAMIS/-д бүртгүүлэн, нэвтрэх эрх авсан. ТХН-ийн данс нээлгэх, үйл ажиллагааны зардлыг тухайн дансанд татан төвлөрүүлэх ажлыг гүйцэтгэлээ. ТХН-ийг улсын бүртгэлд бүртгүүлэж, регистрийн дугаар авсан ба, ТХН-ийн тэмдэг, хэвлэмэл хуудас хэвлүүлэх ажилд хамтран ажиллалаа. Төслийн удирдах хорооны хурлыг хуралдуулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зардлын төсвийн төслийг хэлэлцүүлэн батлуулж, Сангийн яаманд хүргүүллээ.<br>Орхон аймаг Сангийн яам хооронд байгуулах төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний талаар саналыг хүргүүлэн, гэрээ байгуулах тал дээр зөвшилцөлд хүрсэн бөгөөд гэрээ сангийн яаман дээр гарын үсэг зурагдаж байна.<br>Төслийн хэрэгжилтийн явцын талаар төслийн оролцогч талуудын /Захиалагч, Банк, Зөвлөх, ТХН/ цахим хурлыг зохион байгуулж, цаг үеийн мэдээлэл солилцож ажиллалаа. Төслийн хүрээнд Эрдэнэт Ус ДТС ОНӨХК дээр хэрэгжиж байгаа Компанийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сургалт, уулзалт зохион байгууллаа. Мөн төслийн явцын талаар мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж БОАЖЯ-ны мэргэжилтэн, шинжээчдээр хянуулан батлуулж хүлээж авлаа. Төслийн Зөвлөхийн гэрээ дууссантай холбоотой гэрээний хугацааг сунгуулах хүсэлтийг Банканд хүргүүлж, истемд оруулсан.<br>Төслийн ерөнхий мэдээлэл, оролцогч талуудын болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн мэдээлэл, төслийн төсөв, бүрэлдэхүүн хэсэг, хийгдэх ажил, гүйцэтгэгчийн мэдээлэл, явцын гүйцэтгэл, ашиглалтын мэдээ болон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ТХН-ийн 2024 оны улирлын болон жилийн төлөвлөгөө, тайланг Монгол улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (ODAMIS) болон Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд (PIMIS) бүрэн оруулав. Мөн төслийн хэрэгжилттэй холбоотой баримт бичгүүдийг файлын санд орууллаа. | | |
| 2. | 1.2. Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан холбогдох арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь | 70.0 хувь | Арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төслийн хугацааг сунгасантай холбоотой төслийн ажлыг урагшлуулах төслийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг ирүүлэх талаар төслийн гүйцэтгэгч талд албан бичиг хүргүүлсэн боловч гүйцэтгэгч тал төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой үнийн индексжүүлэлт хийх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх тухай санал ирүүлсэнтэй холбоотой энэ талаар мэдээллийг Сангийн яаманд хүргүүлээд байна. Төслийн гүйцэтгэгч талд ажлаа хийхийг шаардсан албан бичиг дахин хүргүүлсэн. Төслийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх, гүйцэтгэгч талыг төслийн талбайд ирж ажиллахыг шаардаж албан бичгүүд явуулж байсан. Гүйцэтгэгч компанийн гүйцэтгэх захирал аймагт ирж ажилласан. Энэ оны 9 дүгээр сарын 20-ноос эхлэн төслийн талбайд ажил эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар Байгууламжийг тойрсон бетон суурьтай хайсан хашааны ажил- | 2024-01-02<br>2024-12-31 | 90% |

25

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 90%, Хатуу хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн сендвичин барилга -90%, Хаалга цонх суурилуулах ажил- 80%, Үйлдвэр хүртэлх шороон замын ажил-95%, Үйлдвэрийн гадна зам талбайн ажил-70%, Эрчим хүчээр хангах агаарын шугамын ажил-100%, Цахилгаан эрчим хүчээр хангах КТП суурьлуулах ажил-95%, Ангилан ялгах тоног төхөөрөмж угсрах ажил-80% байна. | | |
| 3. | 1.3. Аймгийг хөгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөний Зорилт 4.4-т тусгагдсан харилцаа, хамтын ажиллагаатай хөрш орнуудын муж, хотуудтай хамтран эдийн засгийн харилцааг хөгжүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах | Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь | Арга хэмжээнүү-дийн хэрэгжилтийг ханган ажилласан. | Аймгийг хөгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | 1. Дэлхийн банкны хотуудын төслийн хүрээнд хийгдсэн "Монгол улсад дасан зохицох чадвартай, хямд өртөгтэй орон сууцны шийдэл"-ийн судалгааны багтай хамтран ажиллаж, судалгааны үр дүнг урьдчилсан байдлаар танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар судалгааны баг хямд, тэсвэртэй орон сууцны шийдэл, хувилбаруудын талаар судалгааны үр дүнг танилцуулж, 3 багийн иргэдтэй уулзалтыг хийж, судалгаа авав. Судалгааны үр дүнг нэгтгэн 10 дугаар сард танилцуулах уулзалт хийсэн.<br><br>2. БОАЖЯ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран “Цэвэр хот” санаачлагын хүрээнд хэрэгжүүлэх “Хотоос хот руу” хөтөлбөрт аймаг хамрагдах тухай саналыг албан бичгээр хүргүүлсэн. Мөн БОАЖЯ-ны | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Уур амьсгалын өөрчлөлт, бодлого, төлөвлөлтийн газрын дарга, мэргэжилтнүүд, Япон улсын Дэлхийн Байгаль Орчны Стратегийн Институтын төлөөлөлүүд, хэлтсийн мэргэжилтнүүд оролцсон цахим уулзалтаар Орхон аймгийн байгаль орчны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал цаашид анхаарах асуудлуудын талаар англи хэлээр танилцуулга хийлээ. Уулзалтаар ДБОСИ-ийн төлөөлөгчид манай танилцуулгыг сонсон асуулт асууж цаашид хамтран ажиллах чиглэл, төлөвлөгөөг ярилцлаа.<br><br>3. Барилга хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу гадаадын зээл тусламжаар болон аймаг, сум, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн, хийгдэх аймгийн ус, дулаан хангамж, ариутгах татуургын ажлын талаар мэдээллийг 2024 оны байдлаар шинэчлэн албан бичгээр хүргүүлсэн.<br><br>4. Жэрэс /Geres/ олон улсын төрийн бус байгууллагаас удирдан Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Дулаан шийдэл II төслийн 2022-2026 оны хэрэжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймаг орон нутгийг сонгон төслөө тэлэх ажлын хүрээнд аймгийн удирдлагуудтай уулзалт хийж, төслийн судалгаа хийх хүсэлт ирүүлсний дагуу цахим хурлыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгууллаа. Хуралд аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Тамгын газрын дарга Ш.Ганболд, ХБТХОХ-ийн дарга С.Даваадорж, ХЗА-ны дарга Б.Одгэрэл болон төслийн удирдагч болон бусад ажилтнууд оролцож санал солилцон төсөлд хэрэгжүүлэх хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус төсөл аймагтай хамтран ажиллах саналыг төслийн санхүүжүүлэгч байгууллага Европын холбоо дэмжээгүй тухай хариу ирүүлсэн. Тиймээс энэ төсөл өөр аймагт хэрэгжихээр болсон.<br><br>5. БНСУ-ын Газар, дэд бүтэц, зам тээврийн яамны хөгжлийн албан ёсны тусламжаар дэвшилтэт техник технологийг дэлгэрүүлэх зорилготой “Олон улсын хамтын аижллагааны К-хотын сүлжээ хөтөлбөр 2024” хөтөлбөрт хамрагдах аймгийн саналыг аймгийн автозамын сүлжээний өнөөгийн байдлын талаар танилцуулгын хамт хүргүүллээ.<br><br>6. НҮБ-ын Хүүхдийн Сангаас Орхон аймагт хэрэгжүүлэх “Орхон аймгийн сонгогдсон төрийн өмчит барилгуудын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах” төслийн хүрээнд Баян-Өндөр суманд байрлах төрийн өмчит хоёр барилга болох Яргуйт, Баян-Овоот баг болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчний шийдэл ашиглах ажлууд хийгдэх гэж байгаа тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.3 хэсэгт заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлтийг БОАЖГ-т хүргүүлэн үнэлгээ хийлгэж, НҮБ-ийн Хүүхдийн санд албан бичгээр хүргүүллээ.<br><br>7. Аймаг, ЕСБХБ-ны хамтын ажиллагааны хүрээнд шинээр хэрэгжүүлэхээр судалгаа хийгдэж байгаа дэд бүтцийн 3 төслийн судалгааны явцын талаар болон цаашид хамтран ажиллах чиглэлээр Банктай цахим хурал хийсэн.<br><br>8. Орхон аймагт АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн BEST хөтөлбөрийн төслийн үр дүн, тайлан танилцуулга уулзалтад оролцлоо. | | |
| 4. | 1.4. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын | Хөтөлбөр, төслийн хөрөнгө оруулалтын мэдээ, мэдээний орчуулгын тоо хэмжээ | Холбогдох хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүлэн ажилласан байна. | Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнасан байна. | Орхон аймагт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн тайланг 2023 оны эцсийн байдлаар нийт 11 хүснэгтээр нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн хамт Сангийн яаманд тайлант хугацаанд хүргүүлэв. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг тухай бүр гарган холбогдох газар хүргүүлэх, удирдлагуудыг мэдээллээр хангаан ажиллах | | | | Хатуу хог боловсруулах үйлдвэр барих төсөлтэй холбоотой материал /2 удаа 6 хуудас/, "Хотоос хот руу" хөтөлбөрт аймгийн байгаль орчны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд сэдвээр танилцуулга /аман болон бичгийн орчуулга 20 хуудас/ хийсэн байна.<br><br>Төслүүдтэй холбоотой цаг үеийн мэдээллийг тухай бүр дотоод сүлжээгээр, биечлэн ярилцах болон ЗДЗХурлаар удирдлагуудад мэдээлэл хүргэж ажиллав. | | |
| 5. | 1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас гаргасан зөвлөмж, тогтоол, журмуудын дагуу гадаадын зочин төлөөлөгчид орон нутагт ажиллах үеийн тэмдэглэл хөтлөн зохих газар хүргүүлэх | Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Салбарын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Гадаадын зочид төлөөлөгчид орон нутагт ажиллах тухай бүр тэмдэглэл хөтөлсөн байна. | Компанийн хөгжлийн хөтөлбөр болон төслийн гадаад зөвлөхүүд ирж ажилласан болон гадаад мэргэжилтнүүдтэй цахим уулзалт хийсэн тухай тэмдэглэлүүд тус тус хөтөлсөн. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |
| **Зорилт 2. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 6. | 2.1. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын | Үүрэг даалгаврыг биелүүлэн | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд ЗГХЭГ-аас холбогдсоны дагуу хатуу хог ангилах үйлдвэр барих | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биелэлтийг хангах | ажилласан байна. | 100 хувь биелүүлэн ажилласан. | ажилласан байна. | төслийн талаар мэдээллийг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br><br>Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд хамрагдсан.<br><br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр барих, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг Орхон аймагт ажиллахад шаардлагатай мэдээллээр ханган хамтран ажиллалаа. Ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэй, 3 өдөр ажиллав. Ажлын хэсэг төслийн хэрэгжилт, гүйцэтгэлийн нөхцөл байдал, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байдал, нийлүүлсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь техникийн тодорхойлолтыг хангасан байдал, захиалагчийн зүгээс гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байдал, болон бусад үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Ажлын хэсэг хяналт, шалгалтын тухай мэдээлэл, Ерөнхий хянан шалгагчийн албан шаардлагыг бичгээр ирүүлснийг удирдлагуудад танилцуулсан. Албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хариу албан бичгийг хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу “Монгол улсын Засгийн газраас хог хаягдлын талаар баримталж буй үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж байгаатай холбоотой “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр барих, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийн мэдээллийг албан бичгээр хүргүүллээ.<br><br>Мөн тус гүйцэтгэлийн аудит хийгдэж байгаатай холбоотой Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр 2016-2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн мэдээллийг гарган хүргүүлсэн. | | |
| 7. | 2.2. Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргуулахаар тавьсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, удирдлагыг | Хамтран ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байна | Холбогдох хууль дүрмийн хүрээнд асуудлыг шийдвэр лүүлэн ажилласан. | Холбогдох хууль дүрмийн хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэн ажилласан байна. Хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд хяналт тавьсан байна | Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд 36 албан тоот, мэдээлэл боловсруулж холбогдох газруудад шийдвэрлүүлэхээр хүргүүлэн ажиллалаа. Мөн ажлын чиг үүргийн хүрээнд удирдлагаас шилжүүлсэн 48 бичгийг шийдвэрлэж, хяналтанд авч ажиллалаа. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр хангах | | | | | | |
| **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 8. | 3.1.ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан ба биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж байна. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |
| 9. | 3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

31

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ажлын хэсэг, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах | Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна. | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан. | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан байна. | ЗДТГ-ын ХАБЭА-н зөвлөлд ажиллаж, зөвлөлийн ээлжит хуралд оролцож ХАБЭА-н сарын аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэв.<br><br>Бүх нийтээр мод тарих ажилд оролцож Тарлан толгой ууланд хэлтсийн мэргэжилтнүүдийн хамт хавар, намар мод тарьлаа.<br><br>Шинэ хоршоо хөдөлгөөний хойд бүсийн нээлтийн үйл ажиллагааны зохион байгуулалтад ажиллав.<br><br>УИХ-ын болон АНСД-ийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд 12-1-8 дугаар хэсгийн хороонд ажилласан. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аймгийн баяр наадмын үеэр гадаад, дотоодын зочид төлөөлөгчид хүлээн авах ажлын хэсэгт ажилласан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх** | | | | | | | |
| 1. | 2.1. Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа ашиглах, төрийн албаны тухай хуульд заасны дагуу багц сургалтад хамрагдсан байх | Судалсан хууль, тогтоомж, хамрагдсан сургалтууд | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого”-ыг зорилго зорилтыг төрийн албан хаагчдад таниулах сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. | Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна. | Салбарын болон холбогдох чиглэлээр хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулж байна.<br><br>Сонгуулийн тухай хуулийг судлан, сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. /дугаар 135399170654/ | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |
| 2. | 2.2. Гүйцэтгэж буй ажлын чиглэлээр | Салбарын чиглэлийн сургалтууд | Сургалтад хамрагдсан. | Сургалтад хамрагдсан байна. | - Аймгийн Татварын хэлтсээс зохион байгуулсан ХХОАТ-ын талаар сургалтад хамрагдлаа. | 2024-01-02<br>2024-12-31 | 100% |

33

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдлэг, чадвараа дээшлүүлэх | | | | - Сангийн яамнаас зохион байгуулсан “Гадаадын зээл, тусламжийн журмын удирдлага, зохицуулалт” журмын нэмэлт, өөрчлөлтийн танилцуулга цахим сургалтад хамрагдлаа.<br><br>- ТАЗ-өөс явуулдаг дараах 7:4:10 сургалтад хамрагдсан байна. ”Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага”, МУИС-ийн зөвлөх багш, проф Л.Оюун ”Төрийн албаны үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал” МУИС-ийн доктор Ph.D Г.Мягмар<br><br>- Япон улсын сургагч багш Огавагийн “Хүүхдийг хэрхэн үр дүнтэй зэмлэх/магтах” сэдэвт сургалтад хамрагдав.<br><br>- И-оффисын шинэчлэл сургалт<br><br>- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Хяналт үнэлгээний үндэсний хороо хамтран зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт оролцлоо. Сургалтын хүрээнд “Мониторинг хийх нийтлэг журам”, Үнэлгээ хийх нийтлэг журам”, Төрийн байгууллагын гүйцэтгэлийн | | |

34

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удирдлагыг дүгнэх журам" зэрэг журмын төсөлтэй танилцаж, "Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж, анхаарах асуудал, Үнэлгээ, мониторингийн талаарх олон улсын туршлага" зэрэг мэдээлэл авлаа.<br><br>- ТАЗ-ийн "7:4:10" сургалтын "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайллыг дэмжих, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх" сэдэвт вэбинарт хамрагдав. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН: /Д.Сүглэгмаа, Гадаад зээл тусламж, төсөл хөтөлбөр хариуцсан ажилтан/